Шүүх шинжилгээний ерөнхий газрын
2025 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн
04/5628 тоот албан бичгийн хоёрдугаар хавсралт

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

(2025 оны эхний хагас жилийн байдлаар)

Өссөн дүнгээр

№	Шийдвэрийн дэс дугаар	Зүйл заалтын дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар,	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн явц, биелэлт	Үнэлгээ (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал)	Тасарсан болон удааширч байгаа шалтгаан
1	2	3	4	5	6	7	8
в.Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол							
1	54	180	“Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл”-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2018-01-31 Дугаар 2018 №02 ХЗБХ	2.1.2.Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийг таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх, шүүхэд сэтгэл санааны гэм хорыг үнэлэх, тооцох аргачлал, нөхөн төлүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх зэргээр хохирогчийн эрхийг хамгаалах чиглэлээр хууль тогтоомжийн зохицуулалтыг боловсронгуй болгож, хэрэгжилтийг хангах.	Шүүх анагаах ухааны шинжилгээний газрын Шүүх сэтгэцийн шинжилгээний тасагт хүүхдийн эсрэг гэмт хэрэг, хүүхдийн бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч бүхий 201 хүүхдэд гэмт хэргийн улмаас сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэл тогтоох шинжилгээг батлагдсан аргачлалын дагуу хийж гүйцэтгэсэн. Оросын Холбооны Улсад ашиглагдаж буй сэтгэл зүйн шинжилгээний орчин үеийн дэвшилтэт тоног төхөөрөмж, арга аргачлалтай танилцаж, туршлага судлах зорилгоор тус улсын Хууль зүйн яамны харьяа Холбооны шүүх эмнэлгийн төвд 2025 оны 03 дугаар сарын 20-ноос 04 дүгээр сарын 04-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “Сэтгэл зүйн шинжилгээ” сэдэвт сургалтад тус газрын 3 алба хаагч хамрагдсан.	100 Чиг үүргийн хүрээнд хүчирхийлэлийн гэмт хэрэгт өртсөн хүүхдийн сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэл тогтоох шинжилг	-

						ээг батлагдсан аргачлалын дагуу хийж гүйцэтгэж байна. Хэрэгжсэн.	
2		182		3.5.Эрүүл мэндийн яам Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх явцдаа хохирогчийг илрүүлэх, холбогдох байгууллагад мэдээлэх, хохирогчийн бэртэл гэмтэл, өвчлөлийн шалтгааныг тэмдэглэж, баримтжуулж, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан чиг үүргийн хэрэгжилтийг хангаж, ажиллах.	Тус газрын Шүүх анагаах ухааны шинжилгээний газрын Шүүх эмнэлгийн амбулаторийн тасагт 860 бэлгийн холбогдолтой шинжилгээг хүлээн авч дүгнэлт гаргасан байна. Үүнээс 0-3 насны 3, 04-07 насны 17, 08-12 насны 34, 13-17 насны 249 хүүхэд бэлгийн холбогдолтой шинжилгээ хийлгэсэн байна Мөн “Хамгийн чухал нь” зорилтот арга хэмжээний 2-р ээлжээс 7-р ээлж хүртэл “Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг”-ийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдтэй тус байгууллагын 2 сэтгэл зүйч хамтран 17 аймгийн Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын 2645 алба хаагч болон тэдний гэр бүлийн насанд хүрсэн 316 гишүүнд сэтгэл зүйн үнэлгээ хийж, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлж ажилласан. Үзлэг, шинжилгээнд хамрагдсан нийт алба хаагчдыг сэтгэл зүйн байдлаар ангилбал 48.3% нь сэтгэл зүйн хувьд хэвийн (тайван, тогтвортой), 51.6% нь сэтгэл зүйн хувьд тулгамдсан асуудалтай гэх судалгааны дүн гарсан.	100	-
3		185		3.10.Бага насны хохирогч хүүхдийн эрхийг хамгаалахад мэргэшсэн	Тус газрын Шүүх анагаах ухааны шинжилгээний газрын шүүх эмнэлгийн амбулаторийн тасгийн дарга, цагдаагийн дэд	100	-

				өмгөөлөгч, нарийн мэргэшсэн шүүх шинжилгээний шинжээч, хүүхдийн асуудал хариуцсан мөрдөгч ажиллуулах.	хурандаа Ө.Сарангэрэл нь бага насны хохирогч, хүүхдийн эрхийг хамгаалах хүрээний үйл ажиллагаа, сургалт, хэлэлцүүлгийг хариуцан ажиллаж байна. Тайлант хугацаанд Монголын эх барих эмэгтэйчүүдийн эмч нарын холбооноос 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулсан “Эх барих эмэгтэйчүүдийн эмчийн резидентийн хөтөлбөр”-т бэлгийн хүчирхийлэлд өртөгсдөд үзүүлэх эмнэл зүйн тусламж үйлчилгээний талаарх уулзалт, ярилцлагад цагдаагийн дэд хурандаа Ө.Сарангэрэл нь оролцож, санал хүргүүлэхээс гадна 2025 оны 03 дугаар сарын 26-наас 28-ны өдрүүдэд резидент эмч нарт “Биеийн ерөнхий болон бэлэг эрхтний үзлэг, пиктограмм, баримтжуулалт” сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Хүүхдээс үйлдсэн болон хүүхдийн эсрэг үйлдсэн гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, аливаа гэмт хэргийн хохирогч болсон хүүхдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр тодорхой ажил, арга хэмжээг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тус газрын Шүүх эмнэлгийн амбулаторийн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Ө.Сарангэрэл томилогдсон бөгөөд 2025 оны 04 дүгээр сард цахим хурал, 05 дугаар сард ХЗДХЯ-д танхимаар тус, тус хуралд оролцож ажилласан. Байгууллагын хэмжээнд 2025 оны эхний хагас жилийн байдлаар 0-17 насны 1920 хүүхдэд гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ, бэлгийн маргаантай 458 хүүхдэд үзлэг, шинжилгээ хийж, дүгнэлт гарган ажилласан байна.	Хэрэгжсэн . Хүүхдийн асуудал хариуцсан шинжээч томилогдон ажиллаж байна.	

					“Нэг цэгийн үйлчилгээний төв”-д хандсан 55 иргэнд сэтгэл зүй, эрүүл мэнд болон холбон зуучлах үйлчилгээ үзүүлж ажилласан. Үүнээс гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 0-17 насны 6, бэлгийн хүчирхийлэлд өртсөн 0-17 насны 8, нийт 14 хүүхдэд сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ үзүүлж ажиллалаа.		
г.Ерөнхийлөгчийн зарлиг							
4	71	231	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2019-05-30 Дугаар 2019_104	1.8.Нас барагсдын нас барсан шалтгааныг шүүхийн шинжилгээгээр нарийвчлан тогтоох, тоног төхөөрөмжийг боловсронгуй болгох, шинжээч, мэргэжилтнүүдийн ур чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох Яам, агентлагуудад чиглэл өгч шат дараалсан арга хэмжээ авах. Тайлбар: 2022 оны хагас жилийн тайланд хийсэн ХШҮ-ний дагуу энэхүү заалтыг ирүүлэхдээ дараах зүйлийг анхаарна уу: Шинжээч, мэргэжилтнүүдийн ур чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр явуулсан үйл ажиллагааг тусгах	БНСУ-д үйлдвэрлэсэн DM-100MR загварын зөөврийн дижитал рентген аппаратыг 2024 оноос эхлэн ашиглаж байгаа бөгөөд цогцсын рентген шинжилгээг авч гавал, тархины ил болон битүү гэмтэл, цээж хэвлийн хөндий рүү нэвтэрсэн шарх, төрөл бүрийн ослын гэмтэл, гадны биет илрүүлэх, ил, далд хугарал, нас тогтоох зэргийг нарийвчлан тогтоох боломжтой болсон. Тайлант хугацаанд 38 цогцост 212 проекцоор 299 рентген шинжилгээний зураг авч ажилласан. Байгууллагын 2025 оны сургалт, соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөөг 2025 оны 01 дугаар сарын 28-ны өдөр баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тухайлбал, эрх зүйн чиглэлээр 64, удирдах албан тушаалтанд зориулсан 27, хувь хүний хөгжлийн чиглэлээр 71, мэргэжлийн мэдлэг, ур чадварыг сайжруулах чиглэлээр 60, шинжилгээ тус бүрийн чиглэлээр 16, бусад 2, нийт 240 сургалт, арга хэмжээг зохион байгуулсан. Тайлант хугацаанд нийт 65 алба хаагчийг БНСУ, АНУ, БНЭУ, Япон, Тайланд, Турк, ХБНГУ, БНХАУ, ОХУ, Филиппин зэрэг 10 улс оронд зохион байгуулагдсан эрдэм шинжилгээний хурал, олон улсын чуулга уулзалт, симпозиум, мэргэшүүлэх болон мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах, холбогдох бүртгэл, баримт	- МОН-22 төслийн хүрээнд шүүхийн шинжилгээгээр нарийвчлан тогтоох, тоног төхөөрөмжийг боловсронгуй болгох, шинжээч, мэргэжилтнүүдийн ур чадварыг нэмэгдүүлэх чиглэлээр холбогдох сайжруул	-

					бичгийн бүрдүүлэлт, төлөвлөлт, хэрэгжилтийг ханган, зохион байгуулалтыг хийж ажилласан. Үүнээс орон нутгийн 12 алба хаагчийг БНСУ, БНЭУ болон Филиппин зэрэг 3 улс оронд зохион байгуулагдсан мэргэшүүлэх болон мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулсан. Мөн БНСУ-ын Экзим банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлэх "Монгол Улсын Шүүхийн шинжилгээний байгууллагын хүчин чадлыг сайжруулах төсөл (МОН-22)"-ийн хүрээнд БНСУ-ын Сөүлийн үндэсний их сургуульд 2025 оны 03 дугаар сард алба хаагчдыг чадавхжуулах 2 дугаар ээлжийн сургалтад 10 шинжээч эмч нарыг хамруулсан.	алт хийгдэнэ.	
5		232		1.12.Монгол Улсын хэмжээнд амиа хорлох оролдлого хийсэн болон амиа хорлосон тохиолдлыг бүртгэх мэдээллийн сан бүрдүүлж, холбогдох байгууллагуудын нэгдсэн сүлжээтэй болсны үндсэн дээр хүн амд үзүүлэх сэтгэлзүйн тусламж үйлчилгээг хүртээмжтэй болгох	Шүүх шинжилгээний байгууллагын үйл ажиллагааны нэгдсэн систем буюу forensic.nfa.gov.mn цахим хуудасны шинжилгээний бүртгэлийн системийн тоон судалгаанаас үзэхэд 2025 оны эхний хагас жилийн байдлаар дүүжлэлтээр нас барсан гэх хэргийн тохиолдол 239 бүртгэгдсэн байна. Оросын Холбооны Улсын Иркутск хотын Анагаах Ухааны Их Сургуульд 2025 оны 03 дугаар сарын 12, 13-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "Шүүх эмнэлгийн шинжилгээний орчин үеийн асуудлууд" сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хуралд тус газрын Чанарын баталгаажуулалтын хэлтсийн чанарын менежер Б.Ариунзул, Шүүх анагаах ухааны шинжилгээний газрын ахлах шинжээч эмч, цагдаагийн хошууч С.Эрдэнэцэцэг нар оролцож, "Амиа хорлосон тохиолдлуудын өнчин тархины морфологи өөрчлөлтийг хэмжил зүйн 3D программ ашиглан судалсан дүн" сэдэвт илтгэлийг амжилттай хэлэлцүүлсэн.	100 Статистик мэдээлэл гаргаж эрүүл мэндийн яамны системд сар бүр мэдээлдэг. Хэрэгжсэн.	-

					Тус хурлаар шүүх анагаах ухаан, эмгэг судлал, шүүх сэтгэц, шүүх химийн чиглэлээр орчин үеийн судалгааны үр дүн, хамтын ажиллагааны боломжуудыг хэлэлцэж, шүүх эмнэлгийн шинжилгээний төвийн дэвшилтэт зохион байгуулалт, 3D хэмжил зүйн программ ашиглах зэрэг сайн туршлагыг хуваалцсан үр дүнтэй хурал болсон. Мөн Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр зохион байгуулсан “Тодорхой төрлийн гэмт хэргийн нотлох ажиллагааны тулгамдаж буй асуудал (Өндрөөс унах тохиолдлын жишээн дээр)” сэдэвт хэлэлцүүлэгт 5 алба хаагч оролцсон.		
ҮАБЗ-ийн зөвлөмж							
6	74	237	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай 2018-02-05 Дугаар 2018_06/05	1.2.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийн жагсаалтыг тагнуул, цагдаа, шүүхийн шинжилгээ, гааль, мэргэжлийн хяналтын болон холбогдох бусад байгууллагын саналыг авч НҮБ болон ДЭМБ-аас гаргасан жагсаалтыг үндэслэн тухай бүр шинэчлэн батлах санал боловсруулж, холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх	Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис тодорхойлох шинжилгээ хийдэг “Agilent Technologies GC 7820G 5977E MSD хийн хроматограф-масс спектрометр” багажийн CaymanLibrary санд 2025.05.20-ны өдрийн байдлаар шинээр 81 шинэ төрлийн бодисын мэдээллийг нэмж суулган шинэчилсэн. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын шинжилгээний лаборатори нь 2025 оны 02 дугаар сард Хар тамхитай тэмцэх газраас шинжилгээнд ирүүлсэн цэнхэр өнгөтэй шингэнээс манай улсад өмнө нь бүртгэгдэж байгаагүй шинэ төрлийн мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис байж болзошгүй “EDMB-4en-PINACA” нэршилтэй бодис илрүүлсэн. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис тодорхойлох шинжилгээ хийдэг “Agilent Technologies GC 7820G 5977E MSD хийн хроматограф-масс спектрометр” багажны SWGDRUG Mass Specrtal Library санг нийт 3800 бодисын сантай болгон шинэчилсэн.	100 (Салбарыг яамд мэдээллэх)	-

7		240		1.5.Цагдаа, тагнуул, хил, гааль, шүүхийн шинжилгээний байгууллагыг мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг илрүүлэх орчин үеийн техник технологи, багаж хэрэгслээр хангах, ялангуяа энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, таслан зогсоох, илрүүлэх ажлын хүрээнд цагдаагийн байгууллагыг богино хугацаанд тандан илрүүлэх багаж хэрэгслээр яаралтай хангах.	Шүүх шинжилгээний ерөнхий газрын даргын 2025 оны А/06 дугаар тушаалаар Байгалийн ухааны шинжилгээний газрын харьяанд Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын шинжилгээний лабораторийг шинээр байгуулж, алба хаагчдыг томилон ажиллуулж байгаа бөгөөд 2025 оны эхний хагас жилийн байдлаар нийт 1725 шинжилгээ хийгдсэнээс шинжээч эмчийн илгээх бичгээр 1151 шинжилгээ, эрх бүхий албан тушаалтны томилсон тогтоолоор 574 шинжилгээ хийгдсэн байна. Тус лабораторид “Agilent 7900 ICP-MS” тоног төхөөрөмжийг суурилуулж, холбогдох стандарт бодисыг хүлээн авч, шинжээч нарыг сургалтад хамруулсан. Мөн 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас зохион байгуулсан “Донтох эмгэгтэй хүнд үзүүлэх тусламж, үйлчилгээ” сэдэвт сургалтад тус газрын 5 алба хаагч оролцсон. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр зохион байгуулсан “Согтуурах, мансуурах донтой хүнийг эмчлэх эмчилгээний өнөөгийн нөхцөл байдал, цаашдын чиг хандлага” сэдэвт хэлэлцүүлэгт 1 алба хаагч оролцож, санал солилцсон. Үл мэдэгдэх бодисын найрлага, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис тодорхойлох шинжилгээ хийх зориулалттай “FTIR” багаж худалдан авахаар тендер зарлан ажиллаж байна.	100	-
е.Засгийн газрын тогтоол							
8	145	339	. Цахим шилжилтийг эрчимжүүлэх зарим арга	2.Төрийн байгууллага ээрт байгаа, эсхүл нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглан олж авах,	Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжуулан иргэдээс тус байгууллагын шинжээчийн дүгнэлттэй холбоотой 9 гомдол, санал ирүүлсэн.	100	-

			хэмжээний тухай 2024-05-15 Дугаар 2024_215	солилцох боломжтой мэдээллийг хүн, хуулийн этгээдээс шаардахгүй байх, үүнтэй холбогдсон гомдлыг Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвөөр дамжуулан авч, зөрчил гаргасан албан тушаалтанд хуульд заасан үндэслэл, журмын дагуу хариуцлага тооцож байхыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай	Ирүүлсэн гомдол, саналыг судлахад зөрчил тогтоогдоогүй бөгөөд тус газрын 2025 оны 03/830, 06/831, 06/2108, 06/3352, 06/3972 дугаартай албан бичиг болон холбогдох утасны дугаараар хуулийн хугацаанд хариуг иргэнд хүргүүлсэн.		
ЗГ-ын албан даалгавар							
9	250	551	Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсантай холбогдуулан 2024 онд багтаан хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тухай 2024-09-18 Дугаар 2024_01_1	12.5.Төрийн албаны шинэчлэлийг харьяа салбарын хүрээнд манлайлан хууль сахиулах байгууллагын албан хаагчдын сахилга, хариуцлагыг өндөржүүлэх, тус салбар дахь хүний эрхийн зөрчлийг таслан зогсоох цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх.	Тус газрын даргын 2024 оны А/87 дугаартай тушаалаар “Шүүх шинжилгээний байгууллагын Ёс зүйн дэд хороо”-г байгуулсан бөгөөд Монгол Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг байгууллагын хэмжээнд зохион байгуулан ажиллаж байна. Ёс зүйн зөрчлөөс ангид байлгах зорилгоор ёс зүйн “Баталгаа”-ны хуудас гаргаж, алба хаагч нэг бүрээс баталгаа авсан. Тайлант хугацаанд ёс зүйн зөрчилтэй холбоотойгоор 3 алба хаагчаас гаргасан өргөдлийг хүлээн авч, холбогдох журмын дагуу шалгахад 2 өргөдөлд ёс зүйн зөрчил тогтоогдоогүй бөгөөд дүнг Монгол Улсын Ёс зүйн	100	-

					хороонд танилцуулсан. Мөн 1 өргөдлийн хугацаа болоогүй, шийдвэрлэх шатанд ажиллаж байна. *Хамрагдсан сургалт*: Монгол Улсын Ёс зүйн хорооноос 2025 оны 02 дугаар сард зохион байгуулсан “Ёс зүйн дэд хорооны гишүүдийг чадавхжуулах” цахим сургалтад 7 алба хаагч хамрагдсан. *Зохион байгуулсан сургалт, арга хэмжээ:* Тус байгууллагад шинээр томилогдсон 72 алба хаагчийг чиглүүлэх, ажлын байранд дасан зохицоход дэмжлэг үзүүлэх хүрээнд төрийн албан хаагчийн ёс зүй болон авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн цогц сургалтыг зохион байгуулсан. Мөн байгууллагын Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны төлөвлөгөө болон сургалтын төлөвлөгөөний дагуу алба хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 2025 оны 01, 03, 04 дүгээр сард “Ажлын байрны сэтгэцийн эрүүл мэнд, харилцаа хандлага”, “Хайрлахуй”, "Төрийн алба хаагчийн ёс зүй" сэдэвт сургалтыг танхим, цахим хэлбэрээр тус тус зохион байгуулсан. Монгол Улсын Ёс зүйн хорооны гишүүн, М.Цэрэнбатыг 2025 оны 04 дүгээр сард урьж, “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт сургалтыг нийт 248 алба хаагчийг хамруулан зохион байгуулсан. "Эерэг харилцаа, зөв хандлага" аяны хүрээнд Амьдралд ойрхон харилцаа ТББ-ын сургагч багш Ч.Отгонбаярыг урьж, 2025 оны 06 дугаар сард “Эерэг харилцаа, зөв хандлага” сэдэвт сургалтыг зохион байгуулсан.		

ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗАР